БАЙГАЛЬ ОРЧИН, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН ЯАМ

МОНГОЛ УЛСЫН ИХ СУРГУУЛЬ

ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИ

МОНГОЛ УЛСЫН БОЛОВСРОЛЫН ИХ СУРГУУЛЬ

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ, НУТАГ ДЭВСГЭРИЙН ОНЦЛОГИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ

ОЛОН УЛСЫН 3 ДУГААР БАГА ХУРЛЫН ИЛТГЭЛҮҮДИЙН ЭМХЭТГЭЛ

II БОТЬ













Улаанбаатар хот
2017 он

АГУУЛГА

ГАЗРЫН ТӨЛӨВ БАЙДАЛ, АШИГЛАЛТ, ЛАНДШАФТЫН ӨӨРЧЛӨЛТ

О. БАТХИШИГ

ХӨРСНИЙ ЧАНАРЫН ҮНЭЛГЭЭНИЙ АСУУДАЛ ……...1

Д.БАТЦЭЦЭГ, Ч.ЛХАГВАСҮРЭН, О.БАТХИШИГ

БУЯНТ ГОЛЫН ХӨНДИЙН ӨНГӨН ХӨРСӨН ДЭХЬ ЦАЙРЫН (ZN) СУДАЛГАА ……7

Н.МАНДАХ , Ж.ЦОГТБААТАР , Ц.ЭРДЭНЭЦЭЦЭГ , Р.ДЭЛГЭРЦЭЦЭГ

ХУУЧИН ЦЭРГИЙН ЗОРИУЛАЛТААР АШИГЛАГДАЖ БАЙСАН ГАЗРЫН БОХИРДОЛ БА АВАХ АРГА ХЭМЖЭЭ ……..…14

И. МЯГМАРЖАВ, П. МЯГМАРЦЭРЭН

ДАРХАН ХОТЫН ГАЗАР АШИГЛАЛТЫН АНГИЛАЛ, БҮСЧЛЭЛ, ТӨЛӨВЛӨЛТИЙН СУДАЛГААНЫ ҮР ДҮН …23

Б.МИНЖМАА, Т.ОЮУНЧИМЭГ

УЛААНБААТАР ХОТЫН ТӨВЛӨРСӨН ХОГ ХАЯГДЛЫН ЦЭГҮҮДИЙН ХӨРСНИЙ БОХИРДЛЫН ҮНЭЛГЭЭ, ОРШИН СУУГЧДАД ҮЗҮҮЛЭХ НӨЛӨӨЛӨЛ ……....28

Ч. БИЛЭГТМАНДАХ

НУТАГ ДЭВСГЭРИЙН ХӨГЖИЛД БАЙРШЛЫН ХҮЧИН ЗҮЙЛИЙГ ХАРГАЛЗАН ҮЗЭХ НЬ ……..… 34

Ц.АДЪЯАСҮРЭН, Н.АМАРТҮВШИН, Ш.БАТСҮХ,Ч.ТӨМӨРБААТАР,О.ХОНГОРЗУЛ, Ц.ЦЭРЭНДУЛАМ, Б.УРТНАСАН

ЗАРИМ ТХГН-ЫН ОРЧНЫ БҮСИЙН БЭЛЧЭЭРИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ҮНЭЛГЭЭ, БЭЛЧЭЭР НУТГИЙН МЕНЕЖМЕНТИЙГ САЙЖРУУЛАХ АСУУДАЛД ……..…….....47

Б.АЛТАНЦЭЦЭГ, Я.БААСАНДОРЖ, Ш.НАРАН-ОЧИР

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН АРГАЗҮЙН АСУУДАЛ ……...56

А.ДАШЦЭРЭН, Я.ЖАМБАЛЖАВ, Я.ГАНСҮХ

НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН ХӨГЖИЛД ҮЗҮҮЛЖ БУЙ ЦЭВДГИЙН НӨЛӨӨ ……..…….65

Н.МАНДАХ, Д.ДАШ, А.ХАУЛЕНБЕК Ж.ЦОГТБААТАР

МОНГОЛ ОРНЫ ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТЛЫН ТӨЛӨВ БАЙДАЛ ……..…72

Т.ЭНЭРЭЛ, А.ХАУЛЕНБЕК

ЦӨЛЖИЛТ, ГАЗРЫН ДОРОЙТЛЫН НИЙГЭМ, ЭДИЙН ЗАСГИЙН НӨЛӨӨГ ҮНЭЛЭХ АСУУДАЛД ……..…82

Ч. ДАШЗЭВЭГ

ИХ НУУРУУДЫН ХОТГОРЫН БАЙГАЛИЙН НӨХЦӨЛ, НӨӨЦИЙН ОНЦЛОГ …….... 89

Э.НАРАНХҮҮ

УВС АЙМГИЙН НУТАГ ДЭВСГЭРИЙН ЛАНДШАФТЫН ХЭВ ШИНЖҮҮД, ТҮҮНИЙ ТАРХАЛТ, ОНЦЛОГ ……..93

Ц.СЭР-ОД, Д.ДАШ

ХӨХ СЭРХИЙН НУРУУНЫ ЛАНДШАФТЫН ДОТООД ЯЛГАА, ОНЦЛОГ ……...98

Q. WANG, T. OKADERA, ERDENI, M. WATANABE, O. BATKHISHIG

EARLY WARNING SYSTEM FOR VULNERABILITIES OF STEPPE ECOSYSTEMS IN MONGOLIA: CLIMATE CHANGE AND ITS ADAPTATION STRATEGIES ……..103

KH.GERELMAA, D. SURAN, S.TSERENDASH, H. H.BAI

RESULTS OF LONG-TERM MONITORING, EFFECT OF LIVESTOCK GRAZING HIGH BELT MOUNTAIN NORTHERN MONGOLIA ……..107

KH.GERELMAA, D.SURAN, S.TSERENDASH

RANGELAND MONITORING STUDY IN DESERT STEPPE COMMUNITITY OF MONGOLIA ……...116

СУМЫН НУТАГ ДЭВСГЭРИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ БОЛОВСРУУЛАХ АЖЛЫН АРГАЗҮЙН АСУУДАЛ

Б.АЛТАНЦЭЦЭГ[1], Я.БААСАНДОРЖ[2], Ш.НАРАН-ОЧИР[1]

[1]Монголын газар зохион байгуулагчдын холбоо
[2]ШУА-ийн Газарзүй-Геоэкологийн хүрээлэн

Хураангуй,

The land management in our country is implemented involving four different levels of planning process such as state, regional, aimag/city and soum level planning. In developing the land management plan, the resources have been the main focus of the planning process and thus it has been practiced without encouraging the enterprises operating in the territory and citizens in the planning process. Consequently, the local citizens have been kept with a little understanding of the land planning and could not comprehend the essence and importance of land planning. Moreover, the current land plans do not meet the needs and requirements of the present due to their lack of interrelations and relevance. Therefore, it's a necessity that we face today to establish a new phase of land management planning that incorporates soum economic, social and self-governing independent administration matters with multi-land usages and types.

The methodology was developed promoting the concept of "territorial land planning"; and it confirms the basic assumption that it is possible to encourage the local citizens to engage themselves with a mentality of owners of the land and participate actively in the development of their home land, protect and use properly the land they live in.

The territorial land planning methodology provides possibilities to investigate and determine the land resources, properties, and usage status as well as planning the distribution of future usages including what resources would be most effectively used, and to protect. Furthermore, the main concept of the territorial land planning is to build up the local self-governing authorities through securing the rights of its citizens by establishing legally acceptable contracts, engaging them in the planning processes and by making the multi-usages of land resources a transparent process.

ОРШИЛ

Монголчууд эх газрын эрс тэс уур амьсгалтай, хөрсний үржил шим ядуу, ургамлын нөмрөг тачир сийрэг онцлог нөхцөлийг харгалзан дан ганц нүүдлийн мал аж ахуйг эрхлэн аж ахуйн хэрэгцээгээ хангаж ирсэн уламжлалтай.

Өнгөрсөн зууны дунд үеэс нийгмийн хөгжил дэвшилтэй уялдаж газар ашиглалтын хэлбэрүүд шинээр бий болж улмаар газар ашиглалтын уламжлалт арга хэлбэрт өөрчлөлт гарч эхэлсэн. Тэдгээрийн дотор 1990 оноос зах зээлийн харилцаанд шилжиж өмчийн олон хэлбэр бүхий иргэн, аж ахуйн нэгж газрыг олон зориулалтаар ашиглах нийгмийн болон эрх зүйн нөхцөл бүрдэж энэхүү хэрэгцээ шаардлага жилээс жилд байнга нэмэгдэж байна.

Манай оронд газар зохион байгуулалтыг төлөвлөж хэрэгжүүлэх ажил нь улсын газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, бүсийн газар зохион байгуулалтын ерөнхий төлөвлөгөө, аймаг/нийслэлийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө, сум /дүүргийн тухайн жилийн газар зохион байгуулалтын төлөвлөгөө гэсэн 4 түвшинд хэрэгжиж байна. Гэхдээ газар зохион байгуулалтын эдгээр төлөвлөгөөний хоорондын уялдаа холбоо, харилцан хамаарал нь өнөөгийн хэрэгцээ шаардлагыг хангаж чадахгүй байна. Иймд сумын нутаг дэвсгэрийн эдийн засаг, нийгэм, засаг захиргааны хувьд бие даасан, харилцан хамаарал бүхий газар зохион байгуулалтын төлөвлөгөөний шинэ үе шатыг бий болгох шаардлагатай байна. Энэхүү төлөвлөгөөг боловсруулснаар тухайн сумын газрын нөөц, төлөв байдал, газар ашиглалтын байдал зэргийг судалж тодорхойлох, цаашид газрын нөөцийг ямар зориулалтаар хамгийн үр ашигтайгаар зөв хуваарилан төлөвлөж, ашиглаж, хамгаалах боломж нөхцөл бүрдэнэ. Ингэснээр орон нутгийн иргэд, хуулийн этгээд газрын зориулалт, олголтын талаар мэдлэгтэй болж олон хэлбэрээр газар ашиглах эрх баталгаажин байгалийн нөөцийн ашиглалтыг зүй ёсны эрхээр, гэрээгээр баталгаажуулан ашиглах нөхцөл бүрдэнэ.

Газар ашиглалтын олон хэлбэр зориулалт шинээр үүсэн бий болж байгаатай холбогдож газрын эдийн засгийн үр ашиг нэмэгдэх, орон нутгийн хөгжил болон тэнд амьдарч буй ард

иргэдийн амьдралд гарч байгаа эерэг нөлөөлөл гарсан боловч экологийн хувьд эмзэг тогтоцтой газарт үзүүлэх аливаа эрсдэл, ачаалал нэмэгдэж газар нутаг доройтох, бохирдох зэргээр сөрөг нөлөөлөл ч ихээхэн гарч байна.

Иймд газар ашиглалт, хамгаалалтыг сайжруулах, түүний эдийн засгийн үр ашгийг нэмэгдүүлэхэд засаг захиргааны анхдагч нэгж болсон сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний арга зүй боловсруулж, түүнийг хэрэгжүүлэх шаардлагатай байна.

МАТЕРИАЛ БОЛОН АРГАЗҮЙ

Газрын нөөцийг зохистой ашиглах, хамгаалах, байгалийн болон хүний үйл ажиллагааны сөрөг нөлөөллийг бууруулах чиглэлээр газар зохион байгуулалтын төлөвлөгөө боловсруулахдаа дан ганц газрын нөөцөд түшиглэн боловсруулж ирсэн бөгөөд нутаг дэвсгэрт байрлан харьяалагдаж буй аж ахуйн нэгж, иргэдийг төлөвлөлтийн ажилд татан оруулахад тэднийг оролцуулах, идэвхийг өрнүүлэх ажлыг орхигдуулж ирсэн тул орон нутгийн иргэдийн төлөвлөлтийн ажлын ач холбогдлыг талаарх ойлголт муутай явж ирсэн байна. Иймээс шинээр боловсруулж буй сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах аргазүйд газар нутаг, нутаг дэвсгэр гэдэг ойлголтыг хэрэглэх нь орон нутгийн иргэд өөрсдөө газраа зөв зохистой ашиглах, хамгаалах, газар нутгаа хөгжүүлэхэд өөриймсөг сэтгэлгээ төрүүлэхэд тэднийг идэвхжүүлэх боломжтой гэж үзэж байна. Нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтыг төлөвлөж газар ашиглалтын олон зориулалтыг тодотгон ашиглах эрхийг нээж өгч баталгаажуулан төлөвлөгөөнд тусгах шаардлагатай байна. Иймд *сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө* гэдэг ойлголтоор энэхүү арга зүйг боловсрууллаа.

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө /Цаашид нутаг дэвсгэрийн төлөвлөгөө гэх/ гэдэг нь тухайн сумын байгалийн нөхцөл, газар ашиглалтын онцлогийг тодорхойлсны үндсэн дээр сумын буюу орон нутгийн өөрөө удирдах бодлогыг хэрэгжүүлж, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжил болон хүний эрхийг хангахад газрын нөөц баялгийг ашиглах, хамгаалах нөхцлийг тодорхойлоход чиглэсэн цогц үйл ажиллагааг хэлнэ.

Газрын нөөцийн олон талт ашиглалтыг ил тод болгон зүй ёсны эрхийн үндсэн дээр нутгийн иргэдийн эрхийг баталгаажуулах нь нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний арга зүй боловсруулах ажлын суурь үзэл баримтлал болно.

Арга зүйн зорилго. Сумын байгалийн нөхцөл, газар ашиглалтын онцлогийг судалж тодорхойлон, нийгэм эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангахад чиглэгдсэн нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулахад арга зүйн зорилго оршино.

Хамрах хүрээ: Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө нь тухайн сумын газар нутгийг бүрэн хамарна.

Хугацаа: Тухайн сумын хөгжил, нийгэм эдийн засгийн нөхцөл, дээд шатны газар зохион байгуулалтын төлөвлөгөөний хэрэгжилт, аймаг сумын хөгжлийн бодлого зэргээс хамааруулж нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг 6-8 жил хэрэгжүүлж, шинэчлэн боловсруулна.

Баримталсан зарчим: Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулахдаа дараах зарчмыг баримтална. Үүнд:

- *Байгаль орчинд ээлтэй байх зарчим*. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулахдаа тухайн орон нутгийн онцлогийг харгалзан байгаль орчин, экологид ээлтэй байна.
- *Иргэдийн оролцоотой, хэрэгжихүйц, зөрчил багатай байх зарчим.* Орон нутгийн иргэд байгаль орчинтойгоо дасан зохицон эцэг өвгөдөөсөө өвлөж авсан өргөн мэдлэг, байгаль, цаг уур, ургамал, хөрс, ус, нөөц баялаг, зан заншил, өв уламжлал зэргийг тусгасан иргэдийн оролцоотой байна.
- *Үр ашигтай байх зарчим.* Тухайн орон нутгийн газрыг хамгийн үр ашигтайгаар тогтвор суурьшилтай ашиглаж, байгаль орчинд ээлтэй арга технологи хэрэгжүүлэх.
- *Ил тод нээлттэй байх зарчим.* Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө нь иргэд олон нийтэд нээлттэй, энгийн ойлгомжтой байна.
- *Хяналт үнэлгээ хийх боломжтой байх зарчим.* Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний хэрэгжилт болон явцад хяналт хийх боломжтой байна.

СУДАЛГААНЫ ҮР ДҮН

Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулах ажлын үе шат
Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөө нь ажлын дараах үе шаттай байна. Үүнд:

1. Бэлтгэл ажил;
2. Хээрийн хэмжилт судалгаа, тодруулалт, санал хэлэлцүүлэг;
3. Судалгааны үр дүнг нэгтгэх, боловсруулах;
4. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний төсөл;
5. Багийн иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, санал тусгах;
6. Сумын ИТХурлаар төлөвлөгөөг хэлэлцүүлж батлуулах;
7. Нутаг дэвсгэрийн төлөвлөгөө боловсруулж хүлээлгэн өгөх;

Бэлтгэл ажил

Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөний бэлтгэл үе шатанд дараах ажлууд хийгдэнэ. Үүнд:

1. Газар зохион байгуулалтын төлөвлөгөөний материал /улс, бүс, аймаг, сумын тухайн жилийн/
2. Байгалийн нөөц, төрх байдал
3. Нийгэм-эдийн засгийн мэдээлэл
4. Санал, хэлэлцүүлэг болон бусад зэрэг мэдээллийг судлан төлөвлөгөө хийхэд шаардагтай үзүүлэлтийг сонгон авна.

Байгалийн нөөц, төрх байдлын судалгаанд дараах үзүүлэлтийг хамруулна.Байгалийн нөөц, төрх байдлын судалгаанд уур амьсгалын үзүүлэлт, хөрс, ургамал, ой, ус, газрын гадаргын төрх байдал, геологи, зэрлэг амьтны тоо бүртгэл мэдээллийг цуглуулан байгалийн нөөц, төрх байдлын тодорхойлно. Байгалийн нөөцийн шинж төрхийг харуулсан сэдэвчилсэн зураг хийх ба сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд ашиглах зорилгыг нийцсэн шалгуур үзүүлэлтийг сонгон авна. Үүнд:

1. Уур амьсгалын үзүүлэлтэд олон жилийн хур тунадас мм, агаарын болон хөрсний температур ^{0}C, шороон болон цасан шуургатай өдрийн тоо, цасан бүрхүүлтэй өдрийн тоо,
2. Газрын гадаргын төрх байдлын үзүүлэлтэд өндөршилт, налуужилт, байршлын зүг чигийг үзүүлэх бөгөөд өндөршлийн зургийг 900-1000, 1000-1200, 1200-1400, 1400-метрээс дээш гэж ангилан, 30 метрийн DEM зураг ашиглан налуужилтыг 0-3, 3-5, 5-10, 10-12, 12-оос дээш градусаар тооцно.
3. Усан хангамжийн үзүүлэлтэд гадаргын болон гүний усны мэдээлэл,
4. Зэрлэг амьтны үзүүлэлтэд амьтны тархац, байршил,
5. Ургамлын үзүүлэлтэд бэлчээрийн экологийн үндсэн хэв шинж, бэлчээрийн төрөл,
6. Хөрсний үзүүлэлтэд хөрсний хэв шинж, механик бүрэлдэхүүн,
7. Геологийн үзүүлэлтэнд ашигт малтмал, инженер геологийн нөхцөл, байгалийн гамшиг, аюултай үзэгдлийн давтамжийн мэдээлэл зэргийг оруулна.

Энэхүү бэлтгэл үе шатанд судалгаа хийх сумын нутагт хийгдсэн газар зохион байгуулалтай холбоотой судалгаа, байгалийн нөөц, төрх байдал, хөдөө аж ахуй, тусгай хамгаалалттай газар болон ой, усны нөөцийн тогтоох чиглэлээр тухайн суманд хийгдсэн тайлантай танилцаж, газар ашиглалтын зориулалт бүрээр М1:100 000, хот суурингийн газар, аялал жуулчлалын газарт М1:10 000 -аар сэдэвчилсэн зургийн эх хувилбарыг бэлтгэнэ.

Сэдэвчилсэн зургийг ашиглан Газрын харилцаа, геодези зураг зүйн газраас 2015 оны 9-р сард баталсан Газар ашиглалтын тохиромжтой байдлын үнэлгээ хийх аргазүйгээр оновчтой газар ашиглалтыг сонгох анхны сэдэвчилсэн зургийн эхний хувилбарыг бэлтгэн гаргаж хээрийн судалгааны бэлтгэл хангана.

Нийгэм, эдийн засгийн нөхцөлийн судалгаанд дараах үзүүлэлтийг ашиглана. Байгалийн нөөц, төрх байдлын судалгаанд шаардагдах статистик үзүүлэлтүүд болон хүн ам, мал аж ахуй, газар тариалан, уул уурхай, үйлдвэр үйлчилгээ, байгалийн дагалдах баялаг ашиглаж иргэн аж ахуйн нэгжийн мэдээлэл, материаллаг бус газар ашиглалттай холбоотой мэдээллийг хэрхэн олж авах талаар судлан холбогдох хүснэгт, өгөгдлийн мэдээний үзүүлэлтийг гаргаж бэлтгэнэ. Мөн газар ашиглалтаас олж буй орлого, газрын үр ашгийг нэмэгдүүлэхэд оруулж буй хөрөнгө оруулалтыг биет болон мөнгөн мэдээллийг сумын статистикийн мэдээлэлд тулгуурлана гаргана. Нийгэм-эдийн засгийн судалгааны үзүүлэлтүүдийг 5-аас доошгүй жилийн мэдээг хээрийн судалгаа нь үед орон нутгаас гаргуулж авна. Сумын төвийн төсвийн болон үйлдвэр, үйлчилгээ эрхэлж буй иргэд, аж ахуйн нэгжээр ялгаатайгаар бэлтгэж хүснэгтээ бэлтгэнэ.

Нийгэм, эдийн засгийн холбогдолтой судалгаа нь хүснэгтэн болон тоон мэдээлэлд үндэслэх орон нутгийн онцлогт тохируулан боловсруулна. Тухайн сумын газар ашиглалттай холбоотой захирамж шийдвэр болон аж ахуй эрхлэгч иргэн, аж ахуйн нэгжийн орлого, зарлагыг тооцоход зориулсан хуудсыг тоон болон цаасан хэлбэрээр бэлтгэж авна. Эдгээр мэдээлэлд дараах үзүүлэлтүүдийг хамруулна. Үүнд:

1. Тухайн суманд хэрэгжүүлж буй газар зохион байгуулалтын төлөвлөгөө, түүний хэрэгжүүлэхээр гаргасан багийн болон сумын түвшний шийдвэр, газар ашиглагч, эзэмшигч, өмчлөгчийн зүй ёсны эрхийн газрын зориулалт баталгаажуулалт, тоо, газрын төлбөрийн холбогдолтой мэдээлэл,
2. Нийт хүн амын тоо, нас, хүйс, шилжилт хөдөлгөөн, насны ангиллыг 0-16, 16-60, 60-аас дээш,
3. Малчин өрхийг малын тооноос хамааруулан 200 хүртэлх толгой малтай, 200-500 малтай, 500 дээш толгой малтай гэж ангилан тэдгээрийн орлого, зардлыг тодорхойлоход шаардагдах мэдээлэл,
4. Газар тариалангийн үйлдвэрлэлийг тариалан, хадлан эрхэлж буй аж ахуй нэгжийн тоо, тэдгээрийн ашиглаж буй талбайн хэмжээ, үр тариа эрхлэгчдийн талбайг 300 хүртэл га талбай, 300-700 га, 700 га-гаас дээш талбайтай гэж ангилан тухайн аж ахуйн орлого, зарлагын дүнгийн мэдээ болон хураан авч буй ургацын хэмжээг таримлын төрөл болон нийт хэмжээгээр тодорхойлно.
5. Аялал жуулчлал, түүх, соёлын дурсгалт газрыг иргэд, аж ахуйн нэгж сайн дурын болон эрх зүйн хүрээнд ашиглан олж буй орлогыг тодорхойлох боломжтой газрын мэдээлэл авч эдгээр газрын байршлыг тодорхойлох, морин болон явган аялал, амралт, сувиллын газрын байршлыг тогтоох, аж ахуй эрхлэгчдийн тоо, тэдгээрээс олж буй орлогын мэдээ,
6. Үйлдвэр, үйлчилгээний чиглэлээр үйл ажиллагаа явуулж буй нийтийн үйлчилгээний газар, жижиг дунд үйлдвэрлэл болон бусад бизнесийн байгууллагын мэдээлэл.
7. Уул уурхайн ашиглалтын болон хайгуулын лицензтэй газрын байршил, тоо
8. Байгалийн дагалдах баялаг болох жимс жимсгэнэ, загас агнуур болон бусад баялаг ашиглаж байгаа иргэд, аж ахуйн нэгжийн тоо, хээрийн судалгаагаар байршил тогтоох боломж зэрэг болно.

Иргэдийн оролцоотой ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээт байдлыг тогтоохдоо

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд нутгийн иргэдийн оролцоог хангах нь хамгаас чухал. Төлөвлөгөөнд орон нутгийн иргэд оролцож, тэдний санал тусгагдаж байж хэрэгжих боломж хангагдана. Иймээс төлөвлөгөөнд иргэдийг оролцуулах нөхцөлийг бүрдүүлэх шаардлагатай.

Иргэдийн санал бодлыг нутаг дэвгэрийн төлөвлөлтөд тусгуулах, ашиглалтын олон хэлбэр бүхий газрын хэрэгцээг тодорхойлох нь сумын тогтвортой хөгжилд чухал ач холбогдолтой. Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулахад иргэдийн оролцоог хангах үүднээс малчин, тариалан эрхлэгчдийн 15.0%, үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэгчдийн 25.0%, сумын засаг даргын тамгын газрын ажилтнуудын 70.0%-ийг саналын судалгаанд хамруулахаар тооцон холбогдох бэлтгэлээ хийх шаардлагатай.

Газар ашиглалтын онцлог, төрөл болон зорилтот бүлгийн хэлэлцүүлэгт оролцогчийг нас, хүйсээр ялган асуултаа бэлтгэн суманд 8-10 удаагийн хэлэлцүүлэгт бэлтгэн асуултын

судалгааг сумын хүн амын тооноос хамааран олон төрлийн газар ашиглалтын төрлийг гаргах зорилгоор 15 %-иас багагүй хамруулна.

Хээрийн хэмжилт судалгаа, тодруулалт, санал хэлэлцүүлэгт бэлтгэл үе шатанд цуглуулсан хоёрдогч мэдээлэл болон сумын газар ашиглалтын оновчтой байдлын зургийн анхны хувилбарыг хээрийн судалгаанд ашиглан тодруулга хийж газар ашиглалтын хил зааг тогтоох зураглалын суурь материал болно.

Бэлтгэл үе шатанд цуглуулсан суурь судалгааны материал болон газар ашиглалтын оновчтой байдлын зураг газар дээр хэрхэн нийцэж байгаа болон байгалийн нөөцийн ашиглалт болон газар ашиглалтын олон төрлийн зурагт буулгах, иргэдийг хэрхэн төлөвлөлтөд идэвхтэй оролцуулах гэх мэт олон талт үйл ажиллагааг энэ шатанд гүйцэтгэнэ. Хээрийн судалгаагаар хичнээн олон хүн хамруулж хэлэлцүүлэг, ярилцлага зохион байгуулан ярвигтай асуудлыг олон талаас дүгнэн шинжиж нутгийн иргэдийн хамт боломжит хувилбарыг тодорхойлох зэргээр иргэдэд тайлбарлан сурталчилгаа хийнэ төдий чинээ төлөвлөгөө хэрэгжихэд хүндрэл бага гаргана. Хээрийн судалгаагаар дөрвөн үндсэн ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

- Хил зааг, байршил тогтоож зураглах,
- Сумын статистик мэдээ цуглуулах
- Иргэдээс санал авч оролцоог хангах
- Газрын чанарыг тодорхойлох

Хил зааг, байршил тогтоох, зураглах. Хээрийн судалгаагаар газар ашиглалтын хил заагийг тогтоохдоо сумын хил, багийн хилийг оновчтой байдлын зурагт буулгаж дараах газар ашиглалтын төрлөөр зураглана. Үүнд:

1. ХАА-н газар, га
   - *Бэлчээрийн газар ашиглалт:* өвөл, хавар, зун, намар, өвөл-хавар, зун-намар, дөрвөн улирлын, ашиглалтгүй бэлчээр, хашиж хамгаалсан бэлчээр, эрчимжсэн мал аж ахуйн бүс
   - *Тариалангийн газар ашиглалт:* эргэлтийн талбай, тарьсан талбай, уриншилсан талбай, атаршсан газар, үр тариа, төмс хүнсний ногоо, жимс жимсгэнэ, таримал тэжээл
   - *Хадлангийн газар ашиглалт:* ашиглалттай хадлан
2. Хот тосгон бусад суурины газар, га
   - *Суурьшлын бүс:* амины орон сууц, нийтийн орон сууц, гэр хороолол,
   - *Үйлдвэр, үйлчилгээ:* нийтийн үйлчилгээний газар, жижиг, дунд үйлдвэрийн газар
   - *Аялал жуулчлалын газар:* амралт, сувилал, түүх, соёлын дурсгалт газар
   - *Уул уурхай:* ашиглалтын лицензтэй, хайгуулын лицензтэй,түгээмэл болон ховор тархацтай
3. Ойн сан бүхий газар, га
   - Шатсан ой, хортонд нэрвэгдсэн, нөхөн сэргээлт хийсэн, нөхөрлөлийн хил зааг
4. Усны сан бүхий газар, га
   - Гадаргын усны талбайн өөрчлөлт, хүн, малын ундны ус хангамж, усалгаатай газар тариалан, хөв цөөрөм
5. Тусгай хэрэгцээний газар, га
   - *Улсын тусгай хамгаалалттай газар*: дархан газар, байгалийн нөөц газар, байгалийн цогцолборт газар, дурсгалт газар
   - *Улсын тусгай хэрэгцээний газар*: улсын хилийн зурвас газар, батлан хамгаалах аюулгүй байдлын газар, шинжлэх ухаан сорилт туршилтын газар, цаг уур орчны шинжилгээний газар, цөмийн төхөөрөмж барих зориулалтаар олгох газар, аймаг дундын отрын бэлчээр, чөлөөт бүсийн газар, мал тууврын зам орон нутгийн тусгай хамгаалалтай газар болон бусад
6. Зам, шугам сүлжээний газар, га
   - *Авто замын газар:* засмал зам, сайжруулсан зам, шороон зам
   - Төмөр зам
   - Шугам сүлжээ

7. Албан бус газар ашиглалт, га (байгалийн нөөцийн сайн дурын ашиглалт)
   - Жимс жимсгэний тархалт, загас болон зэрлэг амьтны байршил,
8. Байгалийн гамшгийн давтамжтай газарт газрын нэгдмэл сангийн бүх ангилал газар хамаарна, га
9. Газар хөдлөл, үер, мөндөр, мал, амьтны гоц халдварт өвчний голомттой газар, хөрсний бохирдол, гулсалт болон бусад

Эдгээр зураглалыг хийхдээ иргэдийн оролцоог хангах шаардлагатай бөгөөд орон нутгийн төлөөлөлт ашиглагч, эзэмшигч төрийн албан хаагчийн оролцоотойгоор хил заагийг зураглана. Зураг га-гаар илэрхийлнэ, зурагт цэгээр тэмдэглэн байршлыг заана.

Иргэдээс санал авч оролцоог хангах. Иргэдийг төлөвлөлтөд оролцуулах явдал нь энэ арга зүйн гол зорилго болно. Иргэдийн оролцоотой төлөвлөлт гэдэг нь нийгэм, эдийн засгийн зорилгодоо хүрэхийн тулд тухайн орон нутгийнхны өмнө тулгарч байгаа бэрхшээлүүдэд үнэлэлт, дүгнэлт өгч асуудлуудыг шийдвэрлэхэд төлөвлөлтөд ухамсартай бөгөөд мэдрэмжтэйгээр оролцож хариуцлага хүлээх чадвартай иргэдийн оролцоог хангахыг хэлнэ.

Орон нутгийн иргэдийг төлөвлөлтөд оролцуулах, тэдний оролцоотой нүүр тулсан уулзалт, ярилцлага, зорилтот бүлгийн хэлэлцүүлэг, асуулгын судалгаа, хэмжилт зураглал хийх нь төлөвлөлтөд чухал ач холбогдолтой бөгөөд урьдчилан бэлтгэсэн тоон болон чанарын судалгааны асуулга, асуултын хүрээнд хээрийн судалгаа явагдана.

***Уулзалт ярилцлага*:** Сумын газар ашиглалтын одоогийн байдлыг зөв тодорхойлж төлөвлөхөд орон нутгийн иргэдийн оролцоо хамгийн чухал. Сумын засаг дарга, ИТХ-ын дарга болон сумын холбогдох албаны болон нутгаа сайн мэддэг иргэдтэй ганцаарчилсан уулзалт хийхээс гадна эрэгтэй, эмэгтэй хүмүүстэй хэсэг бүрээр ярилцан ажлын зорилго, ажлын төлөвлөгөөгөө танилцуулж орон нутгийн иргэдийн оролцоотой нарийвчилсан төлөвлөгөө боловсруулж хээрийн судалгааны маршрут тогтооно.

Зорилтот бүлгийн хэлэлцүүлэг: Тухайн нутгийн газар ашиглалтын онцлогийг гаргах үүднээс бүлгийн хэлэлцүүлэг хийнэ. Хэлэлцүүлгийг хийхдээ газар ашиглалтын өнөөгийн нөхцөл байдлыг дотоод, гадаад хүчин зүйлээр үнэн зөв тодорхойлох, газрын хэрэгцээ болон газар ашиглалтын нөхцөл байдалд дүн шинжилгээ хийж газар ашиглалтыг сайжруулахад нь туслах зорилготой.

Асуулгын судалгаа: Тухайн сумын нийгэм-эдийн засгийн холбогдолтой судалгааг малчин өрхөөр гаргуулж авна. Судалгаанд малчин өрхийн болон малын тоо, бэлчээрийн даацын хүрэлцээ, улирлын сэлгээ, уст цэгийн тоо болон бусад мэдээлэл багтана. Малчин өрхөөс бэлдсэн хүснэгтийн дагуу гаргуулж авна. Асуулгын судалгаанд малчин өрхийн 15 %-ийг хамруулна. Улирлын бэлчээрийн хил болон бусад зүй ёсны газар ашиглалтын төрлийн хилийг зуруулж авна.

Хэмжилт зураглал: Орон нутгийн судалгааны багийг оролцуулан бэлтгэл шатанд хийсэн оновчтой газар ашиглалтын зургаа ашиглан тодруулалт хийхээс гадна багийн хил, эрчимжсэн мал аж ахуйн бүс, хашиж хамгаалсан бэлчээр, хадлан, улс, орон нутагт байгаа тусгай хамгаалалттай газар, мал тууврын зам, үер, мөндөр зэрэг байгалийн гамшигт өртдөг газрын байршил, хөв цөөрөм байгуулах боломжтой газар, ашигт малтмалын газар, ашиглалтгүй бэлчээр, бэлчээрийн талхлагдал болон газрын нэгдмэл сангийн ангиллаар газар ашиглалтын хил заагийг харуулсан эх зураг гаргана.

Статистик мэдээ.Бэлтгэл ажлын хүрээнд бэлтгэсэн хүснэгтэн мэдээний загвараар сумын статистикийн мэдээллээс газар ашиглалт болон нутаг дэвсгэрийн төлөвлөлтөд шаардагдах дараах тоон мэдээллийг авна. Үүнд дараах мэдээллийг цуглуулна.

Хүн ам:

- Нийт хүн амын тоо, нийт өрхийн тоо, хүйс, шилжилт хөдөлгөөн, нас, насны ангиллыг 0-16, 16-60, 60-аас дээш

Мал аж ахуй:

- Малын тоо, төрөл, малчин өрхийн тоо, 200 хүртэлх малтай, 200-500 малтай, 500 дээш малтай , малчдын орлого, зарлагыг өрх болон багаар гаргах

Газар тариалан:

- Аж ахуйн нэгжийн тоо, эргэлтийн талбай, уриншилсан талбай, атаршсан газар, үр тариа, төмс хүнсний ногоо, тосны ургамал, жимс жимсгэнэ тарьсан талбай, ашиглалттай хадлан, үр тариа эрхлэгчдийн 300 хүртэл га, 300-700 га, 700 га-гаас дээш талбайтай, хураан авсан ургацын хэмжээ,байгалийн болон таримал тэжээл бэлтгэл, хэрэгцээ, аж ахуйн орлого, зарлага,

Материаллаг бус орлого бүхий газар ашиглалт:

- Аялал жуулчлал эрхэлдэг газрын тоо, жуулчдын тоо, амралт сувиллын газар, орлого зарлага, түүх, соёлын дурсгалт газрын тоо,

Үйлдвэр үйлчилгээ:

- Нийтийн үйлчилгээ, жижиг дунд үйлдвэрлэлийн тоо, орлого, зарлага

Уул уурхай:

- Ашиглалтын болон хайгуулын лицензээс орж буй орлого, түгээмэл болон ховор олдоцтой ашигт малтмалын орлого

Байгалийн дагалдах баялаг:

- Жимс жимсгэнэ, загас агнуур, зэрлэг амьтан, орлого

Газрын харилцаа:

- Газар өмчлөгч, эзэмшигч, ашиглагчийн тоо, газрын төлбөр, татвар, газар ашиглалтыг сайжруулах, үр өгөөжийг нэмэгдүүлэхэд чиглэсэн хөрөнгө оруулалт зэрэг болно.

Газрын чанарын өөрчлөлт, доройтол.Нутаг дэвсгэрийн төлөвлөлтөд газрын чанарын өөрчлөлтийг зөв тодорхойлон тусгах нь газар төлөвлөх, ашиглах, хамгаалах, нөхөн сэргээх газрын төлбөрийг тооцох болон газрын менежментийг хөгжүүлэхэд ач холбогдолтой.

Газрын чанарыг тодорхойлдог арга, стандартыг ашиглан газрын чанарын өөрчлөлт, доройтлыг дараах үзүүлэлтээр тодорхойлно. Үүнд:

- Бэлчээрийн ургац, зүйлийн бүрэлдэхүүн, бэлчээрийн багтаамж,
- Бэлчээрийн талхлагдал, зэрэглэл
- Бэлчээрийн хөрсний элэгдэл эвдрэл, зэрэглэл
- Тариалангийн хөрсний элэгдэл эвдрэл, зэрэглэл
- Хөрсний бохирдолт
- Гүний болон гадаргын усны түвшин, бохирдол, чанар

Судалгааны үр дүнг нэгтгэх, боловсруулах. Нутаг дэвсгэрийн төлөвлөлтийн судалгааны бэлтгэл болон хээрийн судалгаагаар цуглуулсан сумын байгалийн нөөц, төрх байдал, нийгэм-эдийн засгийн статистик судалгааны анхдагч мэдээллүүдийг нэгтгэж, үнэлэлт дүгнэлт хийнэ. Энэ үе шатанд хээрийн судалгааны материалыг боловсруулалтыг хийнэ. Боловсруулалт хийсний дараагаар үр дүнг нэгтгэн үнэлэлт дүгнэлт өгөх боломж бүрдэнэ. Иймд судалгаагаар цуглуулсан зурган болон тоон мэдээлэл нь тодорхой зорилготой байх төдийгүй төлөвлөлтийг зөв боловсруулах бололцоог хангасан байх ёстой.

Төлөвлөлтийн өмнөх шат болох бэлтгэл болон хээрийн судалгаагаар тухайн сумын байгалийн болон нийгэм-эдийн засгийн нөхцөлийг хэдий чинээ үнэн зөв, бодитой тогтоож чадна, нутаг дэвсгэрийн төлөвлөлт төдий чинээ чанартай хийгдэж цаашид хэрэгжих боломж бүрдэнэ. Боловсруулалтыг хээрийн судалгаагаар цуглуулсан газар ашиглалтын судалгаа болон сумын нийгэм эдийн засгийн нөхцөл, иргэдийн оролцоо санал дүгнэлтийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусгуулахаар нийцэж байгаа эсэхийг гаргаж ирэх шийдлийг тооцоолж гаргана. Сумын байгаль-уур амьсгалын онцлогт тохирсон, нийгэм-эдийн засгийн хөгжилд ач тусаа өгч буй газар ашиглалтын хэлбэрүүдийг тогтоохын зэрэгцээ газар ашиглалттай холбогдсон хүндрэл бэрхшээлийг анхааран газар ашиглалттай холбогдсон аливаа асуудлыг олон талаас нь судалж, түүнийг шийдвэрлэх арга замыг орон нутгийн удирдлага, иргэдийн санал, хүсэл зорилгод нийцүүлэн төлөвлөж төлөвлөгөөг боловсруулснаар нийгмийн тэгш байдал хангагдах болно.

Сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг оновчтой хийгдсэнээр сумын газрын нөөцийг даац, багтаамжид нь тохируулж зөв зохистой ашиглах төдийгүй нутгийн иргэдийн аж амьдрал сайжирч, төлөвлөгөөг хэрэгжүүлж тухайн сумын тогтвортой хөгжих үндэс болно. Иймээс сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөг хийхдээ сумын нутаг дэвсгэрийн газрын нөөц, ашиглалт, хамгаалахыг

сайжруулах, хөгжүүлэх хөгжлийн тэргүүлэх чиглэлийг тогтоож өгнө. Тэргүүлэх чиглэлээ тогтоосноор нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөнд тусган зорилготой газар ашиглалтыг хөгжүүлэх боломж бүрдэнэ.

Газар нутгийн төлөвлөлтийн төрөл тухайн сумын байршил, байгаль нутаг дэвсгэрийн онцлогоос хамаарч харилцан адилгүй байх бөгөөд дараах төрлүүдийг заавал тусгаж төлөвлөнө. Үүнд:

1. ХАА-н газар нутгийн төлөвлөлт
   - 1.1. Бэлчээр нутгийн төлөвлөлт –
     - 1.1.1. Бэлчээрийн улирлын ашиглалтын төлөвлөлт
       - ✓ Өвөлжөө
       - ✓ Хаваржаа
       - ✓ Өвөлжөө, хаваржаа
       - ✓ Зуслан
       - ✓ Намаржаа
       - ✓ Зуслан, намаржаа
       - ✓ Байнгын буюу улирал
     - 1.1.2. Бэлчээр ашиглалтын төлөвлөлт
       - ✓ Бэлчээр ашиглалтын хэсэг
       - ✓ Усжуулах бэлчээр
       - ✓ Хөцөөлсөн бэлчээр /хашаалах/
       - ✓ Нөхөн сэргээх, хамгаалах
       - ✓ Отрын болон нөөц нутаг
       - ✓ Бусад
   - 1.2. Хадлангийн газрын төлөвлөлт –
     - ✓ Байгалийн хадлан
     - ✓ Таримал хадлан
     - ✓ Хөцөөлсөн хадлан /хашаалах/
   - 1.3. Тариалангийн газрын төлөвлөлт –
     - 1.3.1. Тариалангийн газрын төлөвлөлт - таримлын төрлүүдээр ялгаж төлөвлөнө.
       - ✓ Жимс жимсгэнэ, тэжээлийн ургамал тариалах бүс
       - ✓ Төмс, хүнсний ногоо тариалах бүс
       - ✓ Үр тариа тариалах бүс
     - 1.3.2. Атаршсан болон шинээр эргэлтэнд оруулах тариалангийн газар төлөвлөх
     - 1.3.3. Нэмж тариалан эрхлэх боломжтой тариалангийн газрын төлөвлөлт

Сумын нутаг дэвсгэрийн газар зохион байгуулалтын төлөвлөгөөний тэргүүлэх чиглэл

Монгол Улсын Үндэсний Хөгжлийн цогц бодлого, эдийн засаг нийгмийн хөгжилийн чиглэлүүдтэй нягт уялдуулан сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг хэрэгжүүлэхэд тухайн суманд шаардлагатай тэргүүлэх чиглэлийг тодорхойлно.

Тухайн сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд газрын нөөцийг зөв зохистой ашиглахад сумын тогтвортой хөгжлийн бодлоготой уялдсан иргэдийн амьдралыг дэмжиж байгаль орчинд ээлтэй газар ашиглалтын хэлбэрүүдийг бий болгоход чиглэгдэнэ.

Сумын тэргүүлэх чиглэл нь газрын нөөц, ашиглалтыг сайжруулсан төрийн анхан шатны үйлчилгээний чадавхыг хөгжүүлсэн чиглэл болно. Үүнд:

1. *Сумын тогтвортой хөгжлийг хангах, газар ашиглалт, хамгаалалтыг сайжруулах*
2. *Төрийн үйлчилгээний хүртээмжийг өргөжүүлэх, орон нутагт иргэдийн амьдрах нөхцөлийг бүрдүүлэх*
3. *Байгалийн нөөц, баялгийг түшиглэн байгальд ээлтэй үйлдвэрлэл хөгжүүлэх*
4. *Дэд бүтэц, аялал жуулчлалыг хөгжүүлэх*

Багийн Иргэдийн нийтийн хурлаар хэлэлцүүлэх, санал тусгах. Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулан багийн иргэдийн нийтийн хурал болон иргэдийн түвшинд хэлэлцүүлж багийн ИНХ-ын тогтоол гаргуулах.

Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулан багийн иргэдийн нийтийн хурал болон иргэдийн түвшинд хэлэлцүүлж сумын иргэдээр хэлэлцүүлэн тэдний санал дүгнэлт, газар ашиглалтын төрлийг тогтоосон байдалд нэг бүрчлэн хэлэлцүүлж олонхын саналаар шийдэж БИНХ-ын тогтоол гаргаж баталгаажуулна. Хэрэв багуудын санал зөрүүтэй бол багуудын хамтарсан хурлыг хийж зөвшилцөнө. Багийн хурлаар гарсан саналыг сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөнд тусгана.

Сумын ИТХурлаар төлөвлөгөөг хэлэлцүүлж батлуулах.Нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг сумын иргэдийн хуралд оруулж хэлэлцүүлнэ. Нутгийн иргэд өөрсдөө төлөвлөлтөд оролцсоноор нутаг

дэвсгэрийн төлөвлөгөө зөрчилгүй хэрэгжих магадлал өндөртэй. Иймд сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг баг, сумын иргэдийн хурлаар хэлэлцүүлэн баталгаажуулна.

Багийн түвшинд нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг хэлэлцсэн багийн иргэдийн нийтийн хурлын тогтоол сумын түвшинд сумын иргэдийн төлөөлөгчдийн хурлын тэргүүлэгчдийн тогтоол, энэ тогтоолыг үндэслэн сумын засаг даргын захирамж тус тус гарна. Эдгээр шийдвэр нь нутаг дэвсгэрийн төлөвлөгөө батлагдаж, хэрэгжих үндэслэл болно.

ДҮГНЭЛТ

1. Сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг энэхүү арга зүйн дагуу гүйцэтгэснээр байгалийн нөөц баялгийг зөв зохистой ашиглах нөхцөл бүрдэхийн зэрэгцээ иргэдийн газар ашиглах зүй ёсны эрх баталгаажна. Өөрөөр хэлбэл, сумын нутаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлыг шийдвэрлэхдээ иргэдийнхээ хүсэл зоригт нийцсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ.
2. *Н*утаг дэвсгэрийнхээ эдийн засаг, нийгмийн асуудлыг бие дааж шийдвэрлэх, иргэдийн оролцоотой сумын дунд хугацааны хөгжлийн төлөвийг тодорхойлж, нутгийн өөрөө удирдах байгууллагын эрх хэмжээг өргөжүүлнэ.
3. Архангай аймгийн Эрдэнэмандал, Төв аймгийн Жаргалант, Хэнтий аймгийн Баян-Адарга сумын нутаг дэвсгэрийн төлөвлөгөөг боловсруулж туршилт, судалгаа ажил явуулж энэхүү аргазүйг ашиглах боломжтойг баталсан болно.